



УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2014 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 2415

Улаанбаатар хот

Дүрэм шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан "Улсын бүртгэлийн ерөнхий газрын дүрэм"-ийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын бүртгэлийн ерөнхий газрын орон нутаг дахь бүртгэлийн байгууллагын дүрэм"-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Шинэчилсэн дүрмийг нийт албан хаагчдад танилцуулан, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Тамгын газрын дарга С.Алтангэрэлд үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2009 оны 71 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.ПҮРЭВДОРЖ

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын  
2014 оны 1115 дугаар тушаалын хавсралт

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ОРОН НУТАГ ДАХЬ БҮРТГЭЛИЙН  
БАЙГУУЛЛАГЫН ДҮРЭМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү дүрмээр Улсын бүртгэлийн ерөнхий газар /цаашид "Ерөнхий газар" гэх/-ын Орон нутаг дахь бүртгэлийн байгууллага /цаашид "Бүртгэлийн байгууллага" гэх/-ын үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Бүртгэлийн байгууллага нь Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Засгийн газрын 2013 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан "Улсын бүртгэлийн ерөнхий газрын дүрэм", тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, Ерөнхий газраас өгсөн удирдамж, чиглэлийн дагуу иргэний, эд хөрөнгийн эрхийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг орон нутагт эрхлэн зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

**Хоёр. Бүртгэлийн байгууллагын бүтэц,  
зохион байгуулалт**

2.1. Бүртгэлийн байгууллага нь аймагт хэлтэс, нийслэлд газар, дүүрэгт хэлтсийн зохион байгуулалттайгаар ажиллана.

2.2. Аймаг, дүүрэг дэх бүртгэлийн хэлтэс нь иргэний бүртгэлийн болон эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасагтай, нийслэл дэх бүртгэлийн газар нь захиргааны, архивын хэлтэстэй байна.

**Гурав. Удирдлага**

3.1. Бүртгэлийн байгууллагыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга /цаашид "Ерөнхий газрын дарга" гэх/-ын томилсон дарга /цаашид "Дарга" гэх/ удирдана.

3.2. Дарга нь ажлаа Ерөнхий газрын даргын өмнө хариуцна.

3.3. Дарга нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.3.1. улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулж, бүртгэлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, дээд шатны байгууллагад хүргүүлэх;

3.3.2. улсын бүртгэлийн эх нотлох баримтын архив болон цахим мэдээллийн санг үүсгэх, хөтлөлтөд хяналт тавих, төрөлжүүлэн хадгалах, хадгалалт хамгаалалтын найдвартай байдлыг хангах, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах;

3.3.3. дээд шатны байгууллага, орон нутгийн төрийн захиргааны байгууллага, тэдгээрийн харьяа байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, холбогдох хууль тогтоомжид заасан мэдээ, мэдээллийг гаргаж өгөх;

3.3.4. улсын бүртгэгч болон харьяа дүүргийн улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах;

3.3.5. албан хаагчдын мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх;

3.3.6. албан хаагчдад төрийн албан хаагчийн мэргэшлийн зэрэг дэв олгох болон нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, шагнуулах, сахилгын шийтгэл ногдуулах саналыг Ерөнхий газарт уламжлан, шийдвэрлүүлэх;

3.3.7. "Улсын бүртгэлийн ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журам"-ыг үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж, биелэлтэд хяналт тавьж, энэхүү дүрэм, холбогдох бусад дүрэм, журмаар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд тушаал, шийдвэр гаргах;

3.3.8. улсын бүртгэлийн үйл ажиллагааны тайлан, мэдээг байгууллагын хэмжээнд нэгтгэн гаргах, хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу мэдээлэх;

3.3.9. байгууллагын үйлчилгээний стандарт, улсын бүртгэлийн ажилтны ёс зүйн дүрмийг чанд мөрдүүлж хэвшүүлэх, иргэн, хуулийн этгээдэд бүртгэлийн үйл ажиллагааг сурталчилах;

3.3.10. батлагдсан төсвийн хүрээнд мөнгөн хөрөнгийг зарцуулж, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллах;

3.3.11. санхүү бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, заавар болон Улсын бүртгэлийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайланг гарган тогтоосон хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлэх, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал, ашиглалтад хяналт тавих;

3.3.12. бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой болон албан хаагчдын ёс зүй, зан харьцааны талаар иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг зохих журмын дагуу хянан шийдвэрлэх;

3.3.13. хууль тогтоомж, дүрэм, журмаар олгосон бусад чиг үүрэг.

3.4. Дарга нь хяналтын улсын байцаагч, улсын ахлах бүртгэгчийн эрхтэй байна.

3.5. Даргын түр эзгүйд албан үүргийг Ерөнхий газрын даргын үүрэг болгосноор хэлтсийн дарга, тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч түр орлон гүйцэтгэнэ.

#### **Дөрөв. Бүртгэлийн байгууллагын албан тушаал**

4.1. Бүртгэлийн байгууллагад дараах төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалтан ажиллана:

#### Төрийн захиргааны албан тушаалтан;

4.1.1. газар болон хэлтсийн дарга;

4.1.2. тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч, хяналтын улсын байцаагч, улсын бүртгэгч, мэргэжилтэн;

#### Төрийн үйлчилгээний албан тушаалтан;

4.1.3. архивч;

4.1.4. бүртгэлийн байгууллагад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий бусад албан тушаалтан.

4.2. Албан тушаалтныг дараах эрх бүхий этгээд томилж чөлөөлнө:

4.2.1. энэ дүрмийн 4.1.1-д заасан албан тушаалтныг Ерөнхий газрын дарга;

4.2.2. энэ дүрмийн 4.1.2-т заасан албан тушаалтныг даргын саналыг харгалзан Ерөнхий газрын дарга;

4.2.3. энэ дүрмийн 4.1.3, 4.1.4-т заасан албан тушаалтныг дарга.

4.3. Албан тушаалтныг томилохдоо Ерөнхий газрын даргын баталсан бүтэц, орон тооны дээд хязгаарыг баримтална.

4.4. Дарга нь шаардлагатай тохиолдолд Ерөнхий газрын даргын зөвшөөрсөн орон тоо, төсөв, цаг хугацаанд багтаан төрийн зарим ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

4.5. Албан тушаалтан нь Улсын бүртгэлийн хууль тогтоомж, Ерөнхий газрын даргын тушаал, шийдвэр, дүрэм, журмыг баримтлан, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллана.

#### **Тав. Бүртгэлийн байгууллагын хяналт**

5.1. Бүртгэлийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд Дарга хяналт тавина.

5.2. Бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн байгууллагын хяналтын улсын байцаагч хяналт тавина.

5.3. Хяналтын улсын байцаагч нь Засгийн газрын 2010 оны 47 дугаар тогтоолоор батлагдсан "Улсын бүртгэлийн хяналтын дүрэм", Ерөнхий газрын даргын 2014 оны 856 дугаар тушаалаар батлагдсан "Улсын бүртгэл, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх журам" болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журмыг мөрдөнө.

5.4. Хяналтын улсын байцаагч хяналт, шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Ерөнхий газрын хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжээс өгсөн мэргэжил арга зүйн зөвлөгөө, удирдамжийг удирдлага болгон ажиллана.

5.5. Хяналтын улсын байцаагчийн түр эзгүйд түүний албан үүргийг дарга түр орлон гүйцэтгэнэ.

### **Зургаа. Бүртгэлийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа**

6.1. Бүртгэлийн байгууллага нь санхүү бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, заавар болон Улсын бүртгэлийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайланг дараах хугацаанд гаргана:

- 6.1.1. санхүүгийн сарын мэдээг дараа сарын 2-ны өдрийн дотор;
- 6.1.2. улирлын санхүүгийн тайланг дараа сарын 5-ны өдрийн дотор.

6.2. Дараа жилийн төсвийн төлөвлөгөөний төсөл, санхүүжилтийн хуваарийг тухайн жилийн 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Ерөнхий газарт ирүүлнэ.

6.3. Бүртгэлийн байгууллага нь улсын орлогыг дараа сарын 1-ний өдрийн дотор улсын төсөвт төвлөрүүлнэ.

6.4. Бүртгэлийн байгууллага нь санхүүгийн програм хангамж ашиглана.

### **Долоо. Үйл ажиллагаагаа тайлагнах**

7.1. Бүртгэлийн байгууллага нь үйл ажиллагаагаа "Улсын бүртгэлийн ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журам"-д заасан хугацаанд тайлагнана.

### **Найм. Бусад**

8.1. Бүртгэлийн байгууллага тогтоосон журмаар үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

8.2. Бүртгэлийн байгууллагын тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг Ерөнхий газраас нэгдсэн бүртгэл, хяналтаар олгоно.

--- оОо ---